

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 12 дугаар сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	2010-XI	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-XII
1	Даатгалын компани	16	1 <sup>1</sup>		17
2	Даатгалын компанийн салбар	138			138
3	Даатгалын төлөөлөгч	2022	39 <sup>2</sup>		2061
4	Даатгалын зуучлагч	8	1 <sup>3</sup>		9
5	Даатгалын хохирол үнэлэгч	6			6
6	Актуарч	11	1 <sup>4</sup>		12
7	Бусад		8 <sup>5</sup>		

Тайлант үед даатгалын компанийн салбар, даатгалын хохирол үнэлэгчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 384 дүгээр тогтоолоор “Моннис даатгал” ХХК-д ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;

<sup>2</sup>Хорооны даргын 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 178 дугаар тушаалаар 39 иргэнд “Номин даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;

<sup>3</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 385 дугаар тогтоолоор “Монголиан интернэшнл брокерс” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;

<sup>4</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 388 дугаар тогтоолоор Э.Соёл-Эрдэнэд ердийн даатгалын актуарчийн үйл ажиллагаа явуулах эрх тус тус олгосон.

<sup>5</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 386 дугаар тогтоолоор “Бодь даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500,271,000.0 төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000,543,000.0 төгрөг болгон тогтоохыг;

<sup>5</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 387 дугаар тогтоолоор “УБ даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000.0 сая төгрөг болгон тогтоохыг;

<sup>5</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 416 дугаар тогтоолоор “Монгол траст холдинг даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000.0 сая төгрөг болгон тогтоохыг;

<sup>5</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 417 дугаар тогтоолоор “Ган зам даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000.0 сая төгрөг болгон тогтоохыг;

<sup>5</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 418 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 502,000,000.0 төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000,000,000.0 төгрөг болгон тогтоохыг;

<sup>5</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 420 дугаар тогтоолоор “Жонон даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 525,993,800.0 төгрөг байсныг нэмэгдүүлж 1,025,993,800.0 төгрөг болгон тогтоохыг;

<sup>5</sup>Хорооны 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 419 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд М.Энхболдыг томилохыг;

<sup>5</sup>Хорооны даргын 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 180 дугаар тушаалаар “Түшиг даатгал” ХХК-ийн оноосон нэрийг “Соёмбо даатгал” ХХК болгон өөрчлөхийг тус тус зөвшөөрсөн.

## 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2010 оны 12 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:


### Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2009-ХИ	2010-ХИ
1	Даатгалын нийт хураамж	2,227,608,225.4	2,774,431,724.1
2	Олгосон нийт нөхөн төлбөр	588,724,505.8	621,998,165.8
3	Давхар даатгалд төлсөн хураамж	369,025,725.3	284,598,113.4
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	8,172	10,143
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	27,709,311,500.0	12,773,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	27,130,345.0	51,824,400.0

2010 оны 12 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 546.8 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 33.3 сая төгрөгөөр тус тус өсч, давхар даатгалд төлсөн хураамж 84.4 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант үед шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн 33.9 хувь буюу 96.4 сая төгрөгийг “Тэнгэр даатгал” ХХК, 24.6 хувь буюу 69.9 сая төгрөгийг “Бодь даатгал” ХХК, 18 хувь буюу 51.4 сая төгрөгийг “Гранд даатгал” ХХК, 13.1 хувь буюу 37.4 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК, 10.4 хувь буюу 29.5 сая төгрөгийг “Миг даатгал” ХХК тус тус шилжүүлсэн байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа



**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2009-XII	2010-XII
1	Даатгалын нийт хураамж	11,088,123.0	16,640,138.1
2	Олгосон нийт нөхөн төлбөр	1,000,000.0	5,145,485.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж	3,816,265.5	-
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	19	17
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд		3
	-Байгууллагын хугацаат даатгалд		2
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		-
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		-
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		9
	-Тэтгэврийн даатгалд		2
	-Орон сууцны даатгалд		1
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	20,000,000.0	24,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	1,000,000.0	469,040.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 12 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 5.6 сая төгрөгөөр, нөхөн төлбөр 4.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-X	2010-XI	2010-XII
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	21,348,153.3	29,574,894.9	29,395,964.7
2	Даатгалын зуучлагчийн орлого	6,459,185.1	21,524,396.0	17,037,806.3
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	6	18	34
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3,818,051,962.6	5,138,752,188.0	3,807,505,112.4

2010 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 34 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 17.0 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.